



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 15 өдөр

Дугаар

A/315

Хэрлэн сум

Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1, 13.2.5, 32 дугаар зүйлийн 32.1, 32.1.1, 32.1.2 дугаар зүйл, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3, аймгийн Засаг даргын 2021-2024 оны мөрийн хөтөлбөрийн 4.3.11 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлах, сум орон нутгийн гамшигтай тэмцэх бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлэх зорилгоор гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг тус аймгийн Норовлин суманд 2022 оны 6 дугаар 20-оос 2022 оны 6 дугаар сарын 25-д зохион байгуулсугай.

2.Тус сургуульд шаардагдах 2,452,000 (хоёр сая дөрвөн зуун тавин хоёр мянга) төгрөгийг аймгийн гамшгийн эрсдэлээс хамгаалах сангийн зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

3.Иж бүрэн сургуулийг зохион байгуулах комиссыг нэгдүгээр, зардлын тооцоог хоёрдугаар, удирдамжийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

4.Дээрх арга хэмжээг тусгай удирдамж төлөвлөгөөний дугуу сахилга хариуцлага, чанарын өндөр түвшинд зохисон байгуулж, дүнг танилцуулахыг Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ж.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

06 Аймгийн Засаг даргын 2022 оны
... дугаар сарын 15-ны өдрийн ... А/Б/С
нэг дүгээр захирамжийн хавсралт



ГАМШГААС ХАМГААГ АХ ИЖ БҮРЭН СУРГУУЛЬ
ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Комиссын дарга:	Л.Батсайхан	Аймгийн Засаг даргын орлогч
Сургуулийн удирдагч:	Ж.Эрдэнэбат	Онцгой байдлын газрын дарга, Хурандаа
Нарийн бичгийн дарга:	Ч.Гантогтох	Онцгой байдлын газрын Эрэн хайх аврах салбарын дарга, хошууч
Гишүүд:	Ц.Гэрэлмаа	Зооноз өвчин судлалын төвийн дарга
	Н.Анхбаяр	Мал эмнэлгийн газрын дарга
	Г.Лхагвадорж	Цагдаагийн газрын Нийтийн хэв журмыг хамгаалах тасгийн Дарга, цагдаагийн хошууч

Аймгийн Засаг даргын 2022 оны
 06 дугаар сарын 15-ны өдрийн А/15
 хоёр дугаар захирамжийн хавсралт



Иж бүрэн сургууль зохион байгуулахад
 шаардагдах зардлын тооцоо

Гамшгаас хамгаалах Иж бүрэн сургууль						
			2022 оны 06 дугаар сарын -20- 25-ны өдөр	Шатахууны зардал	Томилолтын зардал	Бусад зардал
1	ОБГ	Норовлин сум		Чингис- Норовлин сум ирж очиход 400 км-т 80 л, дотор 100 км-т 20л нийт 100л 255.000 төг	Сургуулийн бэлтгэл хангах 5 хүн 7 хоног 910.000 төг	Шагнал- 500.000 төг, бодлогын зураг 120.000 төг, аннос 100.000 төг, Нийт 720.000
				Чингис- Норовлин сум ирж очиход 400 км-т 80 л, дотор 100 км-т 20л нийт 100л 255.000 төг	Сургууль удирдах 6 хүн, 2 хоног 312.000 төг	
Нийт 2.452.000 төгрөг						

ГАМШГААС ХАМГААЛАХ ИЖ БҮРЭН СУРГУУЛЬ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг: Зорилго.

Норовлин сумын гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдлыг хангуулж тохиолдож болзошгүй ой, хээрийн болон объектын гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх, хариу арга хэмжээг цаг алдалгүй шуурхай зохион байгуулах, сумын шуурхай штаб, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулж мэдлэг, чадвар олгоход чиглэгдэнэ.

Хоёр: Сургалтанд хамрагдах сум, зохион байгуулах хугацаа.

Гамшгаас хамгаалах Иж бүрэн сургуулийг Норовлин суманд 2022 оны 6 дугаар сарын 20-аас 2022 оны 6 дугаар сарын 25-д зохион байгуулна.

Гурав: Зохион байгуулах ажил.

- Сургалт зохион байгуулах байр танхимыг бэлтгэх.
- Шуурхай штаб, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бэлэн байдлыг шалгаж аранзны үзлэг хийх.
- Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн техник хэрэгслэл багаж зэвсэглэмжийг шалгах.
- Онцгой комисс, бие бүрэлдэхүүнийг 1 дүгээр цагийн байдал дээр ажиллуулах.
- Онцгой комисс, бие бүрэлдэхүүнийг 2 дугаар цагийн байдал дээр ажиллуулах.
- Онцгой комисс, бие бүрэлдэхүүнийг 3 дугаар цагийн байдал дээр ажиллуулах.
- Иж бүрэн сургуулийг дүгнэх, хаах.

Дөрөв: Сургуулийн бэлтгэл ажил хангах ажлыг хэсэг:



Ажлын хэсгийн

ахлагч:	О.Баярмагнай	Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, ахмад
Гишүүд:	Ө.Ганзориг	Ангиллын сургалт, сурталчилгаа урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэрэгжилтэн, хошууч
	Ч.Гантогтох	Эрэн хайх, аврах салбарын дарга, хошууч
	Б.Болор-Эрдэнэ	Гал түймрийн улсын хяналтын байцаагч, Ахмад
	Р.Болор-Эрдэнэ	Шуурхай албаны жолооч, Ахлах ахлагч

Тав: Дүнгийн талаар

Иж бүрэн сургууль зохион байгуулсан дүнг илтгэх хуудсаар бичиж аймгийн Засаг дарга, Онцгой комиссын хурдаанд танилцуулах, цаашид анхаарах, зөрчил дутагдлыг засч арилгах талаар зөвлөмж, үүрэг даалгавар өгөх.

ИЖ БҮРЭН СУРГУУЛЬ ХИЙХ МАРШРУТ



Гамшгаас хамгаалах Команд штабын сургууль					
1	ОБГ	Норовлин сум	2022 оны 06 дугаар сарын 20-25	Шатахууны зардал	Томилолтын зардал
				Чингис-Норовлин сум ирж очиход 400 км-т 80 л, дотор 100 км-т 20л нийт 100л 255.000 төг	Сургуулийн бэлтгэл ажил хангах
			2022 оны 06 дугаар сарын 20-25	Чингис-Норовлин сум ирж очиход 400 км-т 80 л, дотор 100 км-т 20л нийт 100л 255.000 төг	Сургуулийн удирдагч нар

ГАРГАСАН:

АНГИЛЛЫН СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ХОШУУЧ

Ө.ГАНЗОРИГ